

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МАНХАН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/26/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхтулга Утас: 70432545 цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН төгрөгөөр	4
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр	4
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН төгрөгөөр	6
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	7
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН төгрөгөөр.....	7
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН төгрөгөөр	9
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа:	12
Аудитын зөвлөмж:.....	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	12
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	13
1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал	13
2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал	13
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	13

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



МАНХАН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ЭРХЛЭГЧ ИХ ЭМЧ Ж.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>40,724,690.22</u>	<u>54,134,128.95</u>
33	АВЛАГА	92,058.34	548,530.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	92,058.34	73,530.55
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	475,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	40,632,631.88	53,585,598.40
351	Түүхий эд материал	18,516,976.16	28,114,938.68
35130	Эм боох материал	18,516,976.16	28,114,938.68
354	Хангамжийн материал	22,115,655.72	25,470,659.72
35410	Бичиг хэргийн материал	125,003.00	-
35420	Аж ахуйн материал	9,105,408.00	12,851,877.00
35430	Сэлбэг хэрэгсэл	110,000.00	-
35460	Хүнсний материал	2,922,302.00	2,226,530.00
35470	Бусад хангамжийн материал	9,852,942.72	10,392,252.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>571,695,738.74</u>	<u>546,258,642.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	571,695,738.74	546,258,642.27
392	Биет хөрөнгө	551,726,338.82	526,332,992.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	496,874,533.00	496,874,533.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(22,354,252.79)	(38,601,832.43)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	52,261,222.00	54,681,222.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,810,446.13)	(32,510,233.19)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,319,140.82	144,518,840.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(94,131,338.04)	(107,635,529.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,503,211.99	40,503,211.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,935,732.03)	(31,497,220.72)
393	Биет бус хөрөнгө	19,969,399.92	19,925,649.90
39301	Програм хангамж	625,000.00	625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.08)	(493,750.10)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,794,400.00	19,794,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>612,420,428.96</u>	<u>600,392,771.22</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>612,420,428.96</u>	<u>600,392,771.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	612,420,428.96	600,392,771.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	634,389,543.09	634,389,543.09
51101	Өмч: - төрийн	634,389,543.09	634,389,543.09
512	Хуримтлагдсан үр дүн	(27,436,215.46)	(39,463,873.20)
51210	Өмнөх үеийн үр дүн	(27,436,215.46)	(27,436,215.46)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(12,027,657.74)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,467,101.33	5,467,101.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>612,420,428.96</u>	<u>600,392,771.22</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	452,863,058.00	483,131,110.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	429,189,458.00	18,290,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	28,522,222.00	18,290,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,522,222.00	18,290,950.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	440,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,522,222.00	17,850,950.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	400,667,236.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	400,667,236.00	-

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,673,600.00	464,840,160.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	23,594,800.00	370,626,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	23,594,800.00	370,626,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,800.00	18,371,660.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,800.00	18,371,660.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	32,725,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	32,725,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	43,116,300.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	43,116,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	451,539,797.44	495,158,767.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	451,539,797.44	495,158,767.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	451,539,797.44	495,158,767.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,513,839.00	312,997,358.20
210101	Үндсэн цалин	265,374,722.00	312,997,358.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	139,117.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,307,800.99	39,259,469.59
210201	Тэтгэврийн даатгал	23,674,482.41	26,884,625.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,730,547.22	3,162,897.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,158,837.77	2,587,732.72
210204	Ажилгүйдлийн даатгал	513,539.43	602,201.28
210205	Эрүүл мэндийн даатгал	5,230,394.16	6,022,012.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,170,302.00	31,008,843.00
210301	Гэрэл, цахилгаан	2,729,400.00	2,468,343.00
210302	Түлш, халаалт	30,346,700.00	28,540,500.00
210303	Цэвэр, бохир ус	94,202.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	25,616,548.67	23,315,615.00
210401	Бичиг хэрэг	4,112,780.00	3,636,143.00
210402	Тээвэр, шатахуун	15,924,265.00	15,051,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	985,000.00	1,446,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	51,000.00	433,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,671,000.00	388,492.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,872,503.67	2,360,100.00
2105	Нормативт зардал	43,153,027.49	38,628,927.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,035,870.49	30,701,890.48
210502	Хоол, хүнс	8,117,157.00	7,909,037.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	18,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,370,400.00	2,859,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	352,000.00	379,000.00
210604	Урсгал засвар	1,018,400.00	2,480,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,779,000.00	625,000.00
210702	Дотоод албан томилолт	1,779,000.00	625,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,174,930.00	1,079,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	174,930.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	274,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	8,890.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000,000.00	516,110.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,453,949.29	45,385,354.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,372,556.33	3,328,558.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,081,392.96	42,056,796.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,323,260.56	(12,027,657.74)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	566,530.17	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	566,530.17	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(566,530.17)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	756,730.39	(12,027,657.74)

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	424,340,836.00	465,280,160.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	400,667,236.00	440,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	440,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	440,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	440,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	400,667,236.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	400,667,236.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,673,600.00	464,840,160.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	23,594,800.00	370,626,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	23,594,800.00	370,626,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,800.00	18,371,660.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,800.00	18,371,660.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	32,725,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		32,725,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	43,116,300.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		43,116,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	424,340,836.00	465,280,160.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	424,340,836.00	465,280,160.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	424,340,836.00	464,305,160.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,004,000.00	309,723,600.00
210101	Үндсэн цалин	185,708,310.00	211,644,293.00
210102	Нэмэгдэл	57,592,690.00	72,222,407.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	6,600,000.00
210104	Урамшуулал	14,103,000.00	19,256,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,000,500.00	40,414,700.00
210201	Тэтгэврийн даатгал	20,358,000.00	28,440,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,456,672.00	2,993,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,287,228.00	2,394,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	528,000.00	598,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,370,600.00	5,987,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,897,300.00	31,497,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,729,400.00	2,468,343.00
210302	Түлш, халаалт	29,536,700.00	28,540,500.00
210303	Цэвэр, бохир ус	631,200.00	488,857.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,058,960.00	23,779,600.00
210401	Бичиг хэрэг	2,886,300.00	2,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,058,960.00	16,339,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,313,700.00	1,700,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,800,000.00	2,457,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	482,500.00
2105	Нормативт зардал	54,771,176.00	36,438,460.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,175,586.00	28,035,460.00
210502	Хоол, хүнс	8,098,590.00	6,483,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,497,000.00	1,920,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,092,600.00	10,228,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	9,000,000.00
210604	Урсгал засвар	1,092,600.00	1,228,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	625,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	625,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,123,300.00	3,205,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,923,300.00	2,100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,593,000.00	8,393,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,593,000.00	8,393,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	975,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	475,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	475,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	(27,436,215.46)	612,420,428.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	(27,436,215.46)	612,420,428.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	(27,436,215.46)	612,420,428.96
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	(27,436,215.46)	612,420,428.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	(27,436,215.46)	612,420,428.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,027,657.74)	(12,027,657.74)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	(39,463,873.20)	600,392,771.22

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	445,993,500.00	445,993,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	445,993,500.00	445,993,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	445,493,500.00	445,493,500.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,368,600.00	299,368,600.00
210101	Үндсэн цалин	201,379,200.00	201,289,293.00
210102	Нэмэгдэл	72,132,500.00	72,222,407.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	6,600,000.00
210104	Урамшуулал	19,256,900.00	19,256,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,414,700.00	40,414,700.00
210201	Тэтгэврийн даатгал	28,440,000.00	28,440,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,993,700.00	2,993,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,394,900.00	2,394,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	598,700.00	598,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,987,400.00	5,987,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,497,700.00	31,497,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,049,000.00	2,468,343.00
210302	Түлш, халаалт	28,540,500.00	28,540,500.00
210303	Цэвэр, бохир ус	908,200.00	488,857.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,175,700.00	23,175,700.00
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	2,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,175,700.00	16,175,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,000.00	1,700,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,457,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	42,500.00
2105	Нормативт зардал	33,585,700.00	33,585,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,182,700.00	25,182,700.00
210502	Хоол, хүнс	6,483,000.00	6,483,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,920,000.00	1,920,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,228,100.00	5,228,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	1,228,100.00	1,228,100.00
2107	Томилолт, зочны зардал	625,000.00	625,000.00
210702	Дотоод албан томилолт	625,000.00	625,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,205,000.00	3,205,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,100,000.00	2,100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	380,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,393,000.00	8,393,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,393,000.00	8,393,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	445,993,500.00	445,993,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	370,626,400.00	370,626,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	370,626,400.00	370,626,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,725,800.00	32,725,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	32,725,800.00	32,725,800.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,641,300.00	42,641,300.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	42,641,300.00	42,641,300.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	1	1

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,886,200.00	18,811,660.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,886,200.00	18,811,660.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,886,200.00	18,811,660.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	10,355,000.00
210101	Үндсэн цалин	-	10,355,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	106,200.00	603,900.00
210402	Тээвэр, шатахуун	106,200.00	163,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	440,000.00
2105	Нормативт зардал	3,780,000.00	2,852,760.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,780,000.00	2,852,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	5,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,886,200.00	18,811,660.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,886,200.00	18,811,660.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,807,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,800.00	18,371,660.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		440,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Манхан сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч их эмч Ж.Алтангэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч анхан шатны баримт бүрдүүлэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 17-ноос 2021 оны 02 дугаар сарын 18–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Манхан эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны эрхэм зорилго нотолгоонд суурилсан эмнэлгийн тусламж үйлчилгээг хөгжүүлж байгууллагын тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн эрүүл мэндийг дэмжиж байгууллагын эерэг хандлагыг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын харилцаа хандлагыг дээшлүүлж иргэд үйлчлүүлэгчтэй эерэг инээмсэглэл харилцах
- Эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд хүндрэл чирэгдэл гаргахгүй түргэн шуурхай үйлчлэх
- Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж байгууллагыг интернэтийн сүлжээнд холбох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Манхан сумын эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй бөгөөд сумын төрийн сангаас өдөр тутмын гүйлгээнд хяналт хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3-р улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогын 221877.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2218.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 483131.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4831.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Манхан сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11912.01 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Авлага	92.05	548.53	456.48	496%
Бараа материал	40,632.63	53,585.60	12,952.97	32%
Үндсэн хөрөнгө	571,695.74	546,374.28	-25,321.46	-4%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	612,420.42	600,508.41	-11,912.01	-2%
Богино хугацаат өр төлбөр	0	0.00	0.00	
Цэвэр хөрөнгө, өмч	612,420.42	600,508.41	-11,912.01	-2%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	612,420.42	600,508.41	-11,912.01	-2%

Авлага дансны үлдэгдэл 548.53 мянган төгрөг болж 456.48 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд үүссэн 92.05 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 18.52 мянган төгрөгийн барагдуулан ажиллаж тайлант онд нэмэлт данснаас 475.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 53585.60 мянган төгрөг болж 12952.97 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд Ковид-19 цар тахалтай холбоотой эм болон бусад хангамжийн материалыг нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 571695.74 мянган төгрөг, оны эцэст 546374.28 мянган төгрөг болж 25321.46 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн хөрөнгөөр 11399.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймгийн Эрүүл мэндийн газраас 2420.0 мянган төгрөгийн 1 мотоцикл, мөн 2800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж ирж тайлант оны элэгдлийн зардал 42056.79 мянган төгрөг байгаатай холбоотойгоор буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 600508.41 мянган төгрөг болж тайлант онд 11912.01 мянган төгрөгөөр буурсан байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Манхан сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 30268.05 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 30268.05 мянган төгрөгийн орлогоос 22206.46 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 18292.86 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлого өсөж, үнэ төлбөргүй орлого 10231.27 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 40939.3 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 53133.8 мянган төгрөг буюу 17.9 хувиар, хангамж, бараа материалын зардал 1720.6 мянган төгрөг буюу 7.8 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 5135.5 мянган төгрөг буюу 100.4 хувиар, бараа, үйлчилгээний бусад зардал 800.0 мянган төгрөг буюу 10.5 хувиар, урсгал шилжүүлэг 975.0 мянган төгрөг буюу 100 хувиар өссөн, тогтмол зардал 1399.6 мянган төгрөг буюу 4.2 хувиар, нормативд зардал 18332.7 мянган төгрөгөөр буюу 33.4 хувиар, томилолтын зардал 1175.0 мянган төгрөг буюу 65.3 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн, Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 445993.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 445993.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 13/02 тоот тогтоолоор Манхан сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны төсвийг 445993.5 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 445993,5 мянган төгрөгийн төсөв баталснаас 32725.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, тусгай зориулалтын шилжүүлгээр 370626.4 мянган төгрөг, 42641.3 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 32725.3 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалаас 42641.3 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 370626,4 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 445993.5 мянган төгрөг буюу батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 126 хугацаа хоцроож 2, огт мэдээлээгүй 19 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого, зарлагын мэдээлэл, нэмэлт дансны 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг огт мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй тул зөвлөмж, акт, албан шаардлага өгөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт илэрсэн алдаа зөрчилд алдааг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

Аудитын зөвлөмж:

Аудитаар илэрсэн зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар анхаарал татах асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн худалдан авахад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

1.2 Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 126 хугацаа хоцроож 2, огт мэдээлээгүй 19 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого, зарлагын мэдээлэл, нэмэлт дансны 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг огт мэдээлээгүй байна.

2.2 Эрсдэл: Хуулийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх

2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг мөрдөн ажиллаж мэдээллийг цаг хугацаанд бүрэн, үнэн зөв мэдээлэх

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Манхан сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/26/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Манхан сумын Эрүүл мэндийн төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, захилгаар хийгдсэн судалгааны ажлуудад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.	0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч их эмч Нягтлан бодогч	Ж.Алтангэрэл Г.Соёлмаа
2	Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй	0	Зөвлөмж өгөх		
ДҮН					

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР